



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/04

Ховд

Түр хязгаарлалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам, заавар батлах тухай” А/373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний халдварын тархалт нэмэгдэж, аймгийн дэгдэлтийн түвшинд хүрсэнтэй холбогдуулан цэцэрлэг, хүүхдийн сургалтын байгууллага, өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.

2. Тав хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт болон гэрээр асарч байгаа эцэг, эх, асран хамгаалагчдад байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохицуулалт хийж, ажлын цагийн уян хатан нөхцөлөөр хангахыг аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.

3. Цэцэрлэг, хүүхдийн сургалтын байгууллага, өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарласантай холбогдуулан бага насны хүүхдийн хараа хяналтыг сайжруулах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс сэргийлэхийг эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд уриалсугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Энхбаяр), Боловсролын газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан арга зүйч (Б.Анхбаяр), Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүхнаран) нарт, хэрэгжилтэд хяналтад тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0017

Zan A04 Kh